



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/291

Баян-Өндөр сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.2, 11.1.8 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” 03/13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмын хүрээнд зорилтод бүлгийн иргэдэд хүргэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны удирдамж, шаардагдах 49,513,500 (дөчин есөн сая таван зуун арван гурван мянга таван зуу) төгрөгийг “Эрүүл мэндийн салбарын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зардал”-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Л.Галсансайнхувьт)-т зөвшөөрсүгэй.

2. Батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Ц.Мөнхцэцэг), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Наранболд)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ЗОРИГТБАЯР



“ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ИРГЭДЭД ХҮРГЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЬЕ” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

ҮНДЭСЛЭЛ: Орхон аймгийн 30.3 мянган өрх, гэр бүлд 105.9 мянган хүн амьдарч, хүн амын 50.9 хувийг эмэгтэйчүүд, 32.8 хувийг 0-15 насны хүүхэд, 56.9 хувийг 16-59 насны хөдөлмөрийн насныхан, 10.2 хувийг 60 ба түүнээс дээш насны ахмадууд эзэлж байна. Нийт хүн амын 51.1 хувийг эмэгтэйчүүд, 48.9 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна.

Аймгийн хэмжээнд эрт илрүүлэг, үзлэгт хамрагдсан нийт хүн амын 48.2 хувь нь 0-17 насны хүүхдүүд байна. Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 56.9 мянган хүн хамрагдсаны 56.7 хувь нь эмэгтэй, 43.2 хувь нь эрэгтэй бол нийт нас баралтын 62.7 хувь нь эрэгтэйчүүд байна. Нас баралтын 35.4 хувийг зүрх судас, 31.2 хувийг хорт хавдар, 6.5 хувийг осол гэмтэл, гаднын шалтгаант нас баралт эзэлж байна. Дундаж наслалт 2020 онтой харьцуулахад 73.34 болж өссөн хэдий ч, эрэгтэй хүн амын дундаж наслалт эмэгтэй хүн амаас 11.6 насаар зөрүүтэй байгаа юм. 2024 онд шинээр бүртгэгдсэн хавдар өвчний 57.7 хувьд нь эрэгтэйчүүд бүртгэгдсэн.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэнддээ тавих анхаарал, амьдралын хэв маяг зэрэг нь тэдний дундаж наслалтад нөлөө үзүүлэхүйц асуудал болоод байна. Иймд цаашид эрэгтэйчүүдийн дундах эрүүл амьдралын хэв маягийг нэмэгдүүлэх нөлөөллийн ажил болон эрт илрүүлэгт хамрагдалтыг сайжруулах, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эрчүүдийн кабинетын тоног төхөөрөмжийн хангалт 88% байгааг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна.

Орхон аймагт нийт 4582 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт хүн амын 4.3 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 27.0 хувь нь төрөлхийн, 73.0 хувь нь олдмол шалтгаантай бол 45.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Өвчнөөр хөгжлийн бэрхшээлтэй болсон 2669 хүний 87.6 хувь нь ердийн өвчнөөр, 12.4 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөр хөгжлийн бэрхшээлтэй болсон. Осол гэмтлийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй болсон 582 хүний 33.8 хувийг зам тээврийн, 18.5 хувийг үйлдвэрлэлийн осол, 47.5 хувийг ахуйн осол тус тус эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлийг хэлбэрээр нь авч үзвэл хараа 9.1%, сэтгэц 17.0%, хэл яриа 1.8%, хавсарсан 8.2%, сонсгол 8.3%, бусад 34.5%, хөдөлгөөний бэрхшээл 20.6%-ийг эзэлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний 10.8 хувь нь 0-18 насны, 17.3 хувь нь 19-34 насны залуучууд, 64.5 хувь нь 35-64 насны хүн ам, 7.5 хувь нь 65 ба түүнээс дээш насны ахмад байна. Байнгын асаргаанд байдаг 1729 иргэн бүртгэгдсэн нийт

хөгжлийн бэрхшээлтэй хүний 37.7 хувийг эзэлж байна. Хөдөлмөр эрхэлдэг 542, огт сургуульд сурдаггүй 71 хүүхэд бүртгэгдсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмнэлгийн орчинд тусламж үйлчилгээг саадгүй авах нөхцөл боломж, барилга байгууламж, зам талбай, тусгай хэрэгцээнд шаардлагатай хэрэгслээр хангагдсан Эрүүл мэндийн байгууллагын тоо хэмжээг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эмнэлгийн тусламж, асаргаа, сувилгаа, сэргээн засах үйлчилгээний чанар, хүртээмжийг илүү сайжруулах зэрэг хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдлийн 20 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 9.9 промилл байна. Нялхсын эндэгдлийг шалтгаанаар авч үзвэл пренаталь үеийн эмгэг 80 хувийг, осол гэмтэл, гаднын шалтгаант эндэгдэл 10 хувийг тус тус эзэлж байна. Пренаталь эндэгдлийн түвшин өмнөх оноос 4.3 промиллоор өссөн нь улсын дунджаас 2.5 промиллоор өндөр байна. Иймд цаашид Эрүүл эхээс-Эрүүл хүүхэд зарчмын хүрээнд өсвөр үе, залуучууд ялангуяа цэргийн насны эрэгтэйчүүдийн дундах бэлгийн замын халдварыг илрүүлэх, эрүүл мэндийн түвшин болон төрөх насны эмэгтэйчүүдийг эрүүлжүүлэх, тэдний эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, жирэмсний хяналтыг чанаржуулах, эх хүүхдийн тусламж үйлчилгээнд шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангах, нөхөн үржихүй, төрөх, төрсний дараах тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх эрэлт хэрэгцээтэй байна.

Орхон аймагт эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэдийн тоо 2,2%-ийг эзэлж байгаа нь эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чадахгүй байх, хүртээмж буурахад нөлөөлж байна. Монгол улсад Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр хийгдсэн судалгаагаар бүртгэлгүй иргэдийн 75% нь, бүртгэлтэй иргэдийн 35% нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авч чаддаггүй, иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хэрэгцээ их байгаа боловч авч чадахгүй, авсан ч цаг хугацаанд нь чанартай авч чадахгүй байгаа, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад орлогын түвшингээс хамааралтай болон бусад шалтгаант тэгш бус байдал их байгааг нотолсон.

Иймд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмын хүрээнд зорилтот бүлгийн хүн амд эрүүл мэндийн тусламж авах тэгш боломж олгож, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 494 дүгээр тушаалаар батлагдсан тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд зорилтот бүлгийн хүн амд эрүүл мэндийн боловсролыг олгох хэрэгцээтэй байна.

ЗОРИЛГО: Эрүүл мэндийн тусламж авах тэгш боломж олгох хүрээнд зорилтот бүлгийн хүн амд хүргэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлснээр эрүүл мэндийн чанарын үзүүлэлтүүд сайжирч, Тогтвортой хөгжлийн зорилтот түвшинг хангах

ХАМРАХ ХҮРЭЭ: Орхон аймгийн 29 багийн зорилтот бүлгийн 15000 иргэн

ХУГАЦАА: 2025 оны 04 дүгээр сарын 01-нээс 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүртэл нийт 2 сар үргэлжилнэ.

ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГА: Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Жаргалант сумын эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ :

№	Хийх ажлууд	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран ажиллах байгууллагууд	Хамрах хүрээ
1	"Дэлхийн эрүүл мэндийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд сургалт,сурталчилгааны ажлыг зохион байгуулах	2025.04.07	ЭМГ,УТХ, НЭМТ, ЭТҮХ	ЭМБ-ууд	Иргэд, олон нийт
2	"Зөвийг дадал болгоё" шүд угаалгын аварга шалгаруулах тэмцээн	2025.04.01	ЭМГ НЭМТ	БГ, Шүдний мэргэжилтний холбоо	31 цэцэрлэгийн 580 хүүхэд ,асран хамгаалагч нар
3	Нийгмийн эрүүл мэндийн сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах	2025.05.01	ЭМГ НЭМТ	ЭМБ-ууд	Зорилтод бүлгийн иргэд
4	Эрүүл зөв хооллолтын сургалт, өдөрлөг зохион байгуулах	2025.04.15	ЭМГ НЭМТ	ЭМБ-ууд	Иргэд, олон нийт
5	Малчдын эрүүл мэндийн үзлэг,өдөрлөг зохион байгуулах	2025.04.11	ЭМГ, НЭМТ ЭТҮХ	Жаргалант сумын эрүүл мэндийн төв	Жаргалант сумын малчид
6	Сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэг зохион байгуулах	2025.04.01	ЭМГ, НЭМТ ЭТҮХ	Сум,өрхийн эрүүл мэндийн төв, аж ахуйн нэгж байгууллагууд	Эрсдэлт бүлгийн хүн ам
7	HPV-ийн эсрэг дархлаажуулалтад хамралтыг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	2025.04.01-2025.05.30	ЭМГ, НЭМТ	ЭМБ-ууд	БГ, хүүхдийн байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, хэвлэл мэдээллийн алба
8	"Эхийн сүүгээр хооллох, амьдралын алтан 1000 хоног" нөлөөлөл, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах	2025.04.10-2025.12.15	ЭМГ, НЭМТ ЭТҮХэлтэс	ЭМБ-ууд, хувийн хэвшлийн хүүхдийн клиникүүд, НҮТББ	Иргэд, олон нийт
9	"Архи, тамхины өдөр"-ийн хүрээнд сургалт сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах	2025.01.01-2025.05.30	ЭМГ, НЭМТ	ТБ,ТББ	ЭМБ-ууд зорилтот бүлгийн иргэд,олон нийт
10	Эрүүл мэндийн алхалт зохион байгуулах	2025.04.20-2025.05.30	ЭМГ,НЭМТ	Баян-Өндөр сумын ЗДТГ	Иргэд,олон нийт, аж ахуйн нэгж байгууллагууд
11	"Үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулъя" 1 сарын аяныг зохион байгуулж, эмч,эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтад хамруулах	2025.04.01-2025.05.30	ЭМГ, ЭТҮХ	ЭМБ-ууд	Иргэд,олон нийт
12	Хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн болон ахмад	2025.04.14-2025.05.30	ЭМГ, ЭТҮХ	ЭМБ-ууд	Зорилтот бүлгийн иргэд

	настнуудыг үзлэг, оношилгоо, сэргээн засах дасгал хөдөлгөөн, эмчилгээнд хамруулах				
13	Зорилтот бүлгийн даатгалгүй иргэдийн бэлгийн замын халдвар, хавдрын эрт илрүүлэг үзлэг оношилгоо зохион байгуулах	2025.04.10-2025.05.30	ЭМГ, НЭМТ ЭТҮХ	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд	Зорилтот бүлгийн даатгалгүй иргэд
14	Зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг үзлэг, гэр бүл төлөвлөлтөд хамруулах	2025.04.14-2025.05.30	ЭМГ, ЭТҮХ	Сум, ӨЭМТ, БОЭТ, нөхөн үржихүйн клиникүүд	Зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд
15	Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудын албан хаагч, ажилчдыг хамруулж, үр дүнг тооцох	2025.04.01-2025.05.30	ЭМГ, НЭМТ	ЭМБ-ууд	Төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудын албан хаагч, ажилчид
16	Эрүүл мэндийн даатгалд хамрагдах талаар сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах	2025.04.01-2025.05.30	ЭМГ, УТХ	ЭМБ-ууд	Иргэд, олон нийт
17	Цэргийн насны буюу 18-25 насны залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн байдлыг дүгнэх, судалгаа хийх	2025.04.20-2025.05.30	ЭМГ, НЭМТ ЭТҮХ	ЭМБ-ууд	Иргэд, олон нийт
18	"Өсвөр үеийн эрүүл мэндийн 7 хоног"-сэтгэл зүйн сургалт зохион байгуулах	2025.04.04-2025.04.10	ЭМГ, ЭТҮХ	БГ, ХГБХХГ, Сэтгэл зүйч, сум, өрхийн эрүүл мэндийн төв	Өсвөр үеийн хүүхдүүд

**ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ИРГЭДЭД ХҮРГЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСӨВ**

д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа		Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1	Эрүүл мэндийн салбарын нэрэмжит сарын нээлтийн үйл ажиллагаа, "Дэлхийн эрүүл мэндийн өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх	Асар түрээс	8	150.000	1.200.000	ЭМГ НЭМТ	АЗДТГ –ын НБХ, ЭМБ-ууд
		Хөгжим апартура, хөтлөгч	3	196.300	589.000		
		Тайз 6х3	1	500.000	500.000		
		Карказ 4,2 х2,5 түрээс	1	350.000	350.000		
		Анонс 6х3	1	18.500	333.000		
		Эх бэлтгэл	1	20.000	20.000		
		Бөгж	8	1000	8.000		
		Гарын авлага хэвлүүлэх	500	2000	1.000.000		
		Нийт 4.000.000					
		2	"Зөвийг дадал болгоё" шүд угаалгын аварга шалгаруулах тэмцээн	1 хүний шүдний оношилгооны багц	300		
Заалны чимэглэл шаар	1			150.000	150.000		
Шатахууны зардал	50л			2.490	124.500		
1-р байр	1			700.000	700.000		
2-р байр	2			500.000	1.000.000		
3-р байр	2			350.000	700.000		
Нийт 5.374.500							
3	Эрүүл зөв хооллолтын сурталчлах амталгаат,			Хүнсний бүтээгдэхүүний зардал	300	5.000	1.500.000
		Нийт 1.500.000					

	өдөрлөг зохион байгуулах								
	Малчдын эрүүл мэндийн үзлэг, өдөрлөг, сургалт сурталчилгаа зохион байгуулах	Шатахуун	40 л	2490	100000	ЭМГ НЭМТ	Жаргалант сумын ЗДТГ, СЭМТ, малчин иргэд		
		Сургалтын үйл ажиллагааны зардал	5	20000	100.000				
4	HPV-ийн эсрэг дархлаажуулалтад хамралтыг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	ӨЭМТ-ийн урамшуулал	1	1.000.000	1.000.000	ЭМГ НЭМТ	11-14 насны хүүхдүүд, асран хамгаалагчид		
			1	500.000	500.000				
		ЕБС-ын урамшуулал	1	1.000.000	1.000.000				
			1	500.000	500.000				
		Вакцинаторын урамшуулал	1	500.000	500.000				
			1	300.000	300.000				
		Эмчийн урамшуулал	2	400.000	800.000				
5			2	200.000	400.000				
		Нийт 5.000.000							
		Явуулаар үзлэг хийх шатахуун	361 л	2.490	900.000			ЭМГ НЭМТ	Зорилтод бүлгийн иргэд
		Зорилтот бүлгийн иргэдэд мэдээлэл хүргэх утасны нэгж	10	10.000	100.000				
		Нийт 1.000.000							

7	Нийгмийн эрүүл мэндийн сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах	Сургалтын хэрэглэгдэх үүний зардал	50	10.000	500.000	ЭМГ НЭМТ	29 багийн иргэд
			Нийт 500.000				
8	"Архи, тамхины өдөр"-ийн хүрээнд сургалт сурталчилгаа, үйл нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах	Сургалтын хэрэглэгдэх үүний зардал	500	1.000	500.000	ЭМГ НЭМТ	ЭМБ-ууд зорилтот бүлгийн иргэд, олон нийт
			Нийт 500.000				
9	"Өсвөр үеийн эрүүл мэндийн 7 хоног"-сэтгэл зүйн сургалт зохион байгуулах	Сургалтын хэрэглэгдэх үүний зардал	100	5.000	500.000	ЭМГ	БГ,ГБХХХГ, Сэтгэл зүйчдийн баг ЭМБ-ууд
			Нийт 500.000				
10	"Үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулъя" аяныг зохион байгуулж, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтад хамруулах	Байгууллага 1-р байр 2-р байр 3-р байр Шилдэг менежер Өргөмжлөл Цайны зардал 2 удаа Хоолны зардал	1 1 1 1 4 150 150	500.000 300.000 200.000 500.000 50.000 6000 28.000	500.000 300.000 200.000 500.000 200.000 900.000 4.200.000	ЭМБ-ууд	Иргэд,олон нийт, эрүүл мэндийн байгууллагууд

	Заалны түрээс	1	1.000.000	1.000.000	
	Сургагч багшийн замын зардал /ирэх,буцах/	3	69000	414.000	
		Нийт 8.214.000			
11	Зорилтот бүлгийн даатгалгүй иргэдийн бэлгийн замын халдвар, эрт илрүүлэг үзлэг оношилгоог зохион байгуулах	Бээлий хос N50	60	14.000	840.000
		Спирт хөвөн N20	264	1470	389.000
		Өндөг цоологч	106	5000	530.000
		Хогийн уут N 30	5	7000	35.000
		Аюулгүй хайрцаг	30	2700	81.000
		Тэмбүү,ДОХ -ын оношлуур	1500	4500	6.750.000
		Нийт 8.625.000			
12	Цэргийн насны буюу 18-25 насны залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн байдлыг дүгнэх,судалгаа хийх	Тэмбүүгийн оношлуур	800	4500	3.600.000
		Эмч нарын хоолны зардал	10	50.000	500.000
		Нийт 4.100.000			
13	Зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг үзлэг, гэр бүл	Тэмбүүгийн оношлуур	500	4.500	2.250.000
		Эхо оношилгооны зардал	550	5000	2.750.000
		Зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүд			
		Сум,ӨЭМТ, БОЭТ, нөхөн үржихүйн клиникууд			
		Цэргийн насны 18-25 насны залуучууд			
		ЭМГ СӨЭМТ Хувийн хэвшлийн нөхөн үржихүйн клиникууд			

	төлөвлөлтөд хамруулах	Нийт 5,000,000					
14	“Эхийн сүүгээр хооллох, амьдралын алтан 1000 хоног” нөлөөлөл, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах	Ээжүүдийн “Алтан 1000 хоног” нөлөөллийн үйл ажиллагааны зардал	1000	5,000	5,000,000	ЭМГ НҮТББ	Иргэд, олон нийт
		Нийт 5,000,000					
Нийт бүгд 49,513,500							

00